

## СҮН ЯТ СЭН “ТАВАН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН ЗАРЧМУУД<sup>59</sup>”

Орос хэлнээс орчуулсан: Г.Цэнд-Аюуш

*МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, дэд профессор*

Дорно дахины улс төрийн сэтгэлгээний сургаал номлолын онцлог бол нийгэм, төрийн оршин тогтнол, хөгжил дэх уламжлалт ёс журмыг гол болгодог. Энэхүү уламжлал нь нийгмийн болон төрийн зохион байгуулалтын амин чухал зарчмууд, суурь үнэт зүйлсийн цогцыг өөртөө агуулж байдаг. Тиймээс дорнын төр улсуудын хувь заяанд барууны үнэт зүйлс нөлөөтэй байсан хэдий ч уламжлалт зарчмууд хадгалагдаж ирсэн юм. Хятадын их сэтгэгч, нийгмийн зүтгэлтэн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчдийн нэг Сүн Ятсэний 1924 онд бичсэн “Таван засаглалын үндсэн зарчмууд” хэмээх өгүүллийг орчуулан толилуулж байна. Энэхүү өгүүлэлд дэвшүүлсэн Сүн Ятсэний ардчилсан үзэл санаа өнөөгийн Монголын оршин тогтнож буй төрийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох улмаар төрийн түшээд, албан тушаалтнуудыг шилж сонгох, тэдний албан үүрэг хариуцлагыг дээшлүүлэх үйл явцад илүү их үр дүнтэй рациональ механизм байж болох талтайг үгүйсгэх аргагүй.

Сүн Ятсэн (1866-1925). Тэрбээр 1911 оны Синхайн хувьсгал ялсны дараа Хятад ард улсын анхны ерөнхийлөгч болсон. Сүн Ятсэний улс төрийн номлол нь Хятадын нөхцөлд тохирсон ардын гурван зарчмын тухай сургаал, таван засаглалын онолыг багтааж байдаг. Ардын гурван зарчим нь үндэсний үзэл, ардын сайн сайхан байдал, ард түмний засаглалаас бүрдэнэ. Үндэсний үзлийн зарчим Хятадын бүх үндэстэн ястны бүрэн тэгш эрхийн шаардлага, гаднын дарлалын эсрэг тэмцлийн үзэл санааг илэрхийлнэ. Ардын сайн сайхан байдлын зарчим газар тариалангийн шинэтгэл хийх, улс орны аж үйлдвэржилтыг хэрэгжүүлэхтэй холбогдоно. Ард түмний засаглалын зарчим улс төрийн эх дүр болсон үзэл баримтлал болох-таван засаглалын үндсэн зарчмуудтай холбоотой юм. Сүн Ятсэн олонх орнуудад байдаг гурван засаглалын систем (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхийн) ардчилсан институтуудийн хэвийн ажиллагааг хангаж чадахгүй байгаа учир шалгалтын болон хяналтын гэсэн хоёр засаглалын механизмыг бий болгох хэрэгтэй гэж үзсэн. Нөгөө талаар Сүн Ятсэн тоталитар болон авторитар уламжлал хүчтэй байсан улс орнуудад ардчиллыг хэрэгжүүлэхэд нийгмийн мөргөлдөөн гарах явдлаас зайлсхийх үйл явц алгуур өрнөх ёстой. Үүнтэй түүний захиргааны гурван үе шатны үзэл санаа (цэргийн захиргаа, улс төрийн хамгаалал, үндсэн хуулийн захиргаа) холбоотой. Энэ номлолыг 1920-1930 онуудад Хятадад хэрэгжүүлэхийг оролдож байжээ. Тайванд түүний үзэл санаа эрх баригч Гоминданы намын албан ёсны номлол болж байсан учир шалтгаанаар тэнд түүнийг “ төр улсын эцэг” гэж нэрийддэг байна.

<sup>59</sup> Сүн Ят сэн. Конституция пяти властей. Р.Т.Мухаев. Политология/Хрестоматия/М., 2000

Таван засаглалын үндсэн зарчмууд:

Таван засаглалын үзэл санаа зөвхөн минийх. Аль ч улс оронд ийм үзэл санаа хэзээ ч дэвшигдэж байгаагүй. Сүүлийн зуугаас хоёр зуун жилийн туршид дэлхийн улс төрийн сэтгэлгээний хөгжил үндсэн хуулийн захиргааны тал руу анхаарлаа хандуулж ирсэн нь хэн бүхэнд илэрхий. Сүүлийн арав хорин жилд “үндсэн хуулийн захиргаа” хэмээх илэрхийлэл бидэнд дасал болсон. Үндсэн хууль гэж юу вэ?. Төр улс дахь улс төрийн засаглал нь бие биенээсээ хараат бус өөр өөрийн онцгой тогтсон зориулалт бүхий хэд хэдэн хүрээнд хуваагдсан байхыг зөвшөөрсөн хуулийг хэлнэ гэж хамгийн энгийнээр ойлгож болно. Эдүгээ үйлчилж байгаа үндсэн хуулиудаар дэлхийн улс орнууд дахь улс төрийн засаглал гурван хүрээнд хуваагдсан байх агаад тэдгээрийг гурван засаглал гэж нэрлэдэг. Нэг ч үндсэн хуульд хэзээ ч таван засаглалын оршин тогтнолыг тусгаагүй. Таван засаглалын үндсэн зарчмуудыг миний бие боловсруулсан. Түүний үндэс нь юунд оршиж байгааг олон хүмүүс сайн ойлгоогүй. Үнэнээ хэлэхэд олон орны үндсэн хуулийг судалсаны дараа энэхүү үзэл санаа надад төрсөн юм.

Дэлхий дээр бүхнээс түрүүн АНУ үндсэн хуулиа тунхагласан. Америкт гарсан хувьсгалын үр дүнд английн дарлалыг таягдан хаяж бүгд найрамдах улс болж гурван засаглал бүхий үндсэн хуулийг тогтоосон. Тухайн үедээ төр улс, ард түмний сайн сайхан байдлыг үндэс болгосон зарчмуудыг бичмэлээр маш нарийн нягт нямбай тусгасан баримт бичиг болсон. Хожим нь бусад олон орон төр улсынхаа үндсэн хуулийг боловсруулахдаа америкийн үндсэн хуулийг жишиг загвар болгож байсан. Тэр хуулийн ач холбогдол агуу байсан болохоор миний бие түүнийг маш ихэд нягтлан гүн хүндэтгэлтэй судалсан.

Тухайн үедээ Америкийн үндсэн хууль хамгийн шилдэг хууль байсан нь үнэн боловч өнөөгийн өнцгөөс харахад америкийн эрдэмтдийн дотор ч өөрийнхөө үндсэн хуулийг боловсронгуй болгох санаа сэдэл гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ үндсэн хуулиар Америкийн олонх муж улсуудад сонгуулийн зарчим үйлчилж ирсэн. Хичнээн сайн сонгууль байлаа ч хэнийг сонгох вэ? гэдэг асуудалд бүрэн дүүрэн хариулт өгч чаддаггүй. Бүх нийтийн сонгуульд тодорхой шалгуур тавихгүйгээр албан тушаалаа урвуулан ашиглах явдлаас зайлсхийж чадахгүй. Сонгогдсон төрийн түшээд тодорхой хэмжээний чадамжтай байх ёстой. Миний үзэж байгаараар парламентийн гишүүн эсвэл төрийн албан тушаалтан ёс суртахууны чанар, авъяас билиг, чадамжтай чанараараа бусдаас ялгарч байх ёстой. Тэгж байж тэр хүн албан үүргээ жинхэнэ ёсоор гүйцэтгэж чадна. Ёс суртахууны чанар, авъяас билиг, чадамжгүйгээр парламентийн гишүүн эсхүл түшмэд болно гэдэг нь утгагүй зүйл. Жишээ татахад: сонгогдсон 50 хүнээс хамгийн шилдэг сайныг нь ёс суртахууны чанар, авъяас билиг, чадамжаар нь ялган салгахад бэрхтэй.

Хятадад аль эртнээс дээрх шалгуурыг тогтооход нэг сайн арга ашиглагдаж ирсэн. Энэ бол шалгалт. Төрийн түшмэлийг ажил албанд томилогдохоос нь өмнө шалгалт авч байсан. Шалгалтгүйгээр төрийн түшээдийг тохоон томилдоггүй байсан. Хаант засгийн үед төрийн албан тушаалд

шалгалтгүйгээр томилогддог байсан бол Бүгд найрамдах засгийн үед шалгалтын систем бол хамгаас чухалд тооцогдох ёстой. Энэ учраас би уламжлалт гурван засаглалын зэрэгцээгээр дөрөв дэх засаглал болсон шалгалтын засаглалын үзэл санааг дэвшүүлж байна.

Шалгалтын систем бол маш сайн систем. Би гадаад орнуудад цагаачилсан он жилүүддээ олон орны улс төрийн систем, үндсэн хуулийг судлаад шалгалт бол аливаа дутагдалыг засах хамгийн найдвартай арга хэрэгсэл мөн гэдэгт гүнээ итгэсэн. Энэ арга хэрэгсэл гадаадын эрдэмтэдээс хуулбарлаж авсан зүйл биш миний бие өөрөө энэ арга хэрэгслийн механизмыг дэвшүүлж байгаа юм. Үндсэн хуулийг илүү боловсронгуй болгох түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад тотгор болдог дутагдалыг устгаж арилгахад энэхүү шалгалтын арга хэрэгсэл хамгаас чухал. Хятад улс баян хүчтэй төртэй болохын тулд юу хийх ёстой вэ? Үүний тулд таван засаглалын үндсэн зарчмыг хэрэгжүүлэх ёстой. Бусад орнуудыг бодвол Хятад дахь улс төрийн байгуулал бүх цаг үеүдэд өөрийн онцлогтой оршиж ирсэн. Хятадад улс төрийн хөгжил эрх чөлөөнөөс деспот /дарангуйлалын/ дэглэмд шилжих байдлаар явагдаж ирсэн бол бусад орнуудад эсрэгээрээ деспот дэглэмээс эрх чөлөөт дэглэм рүү шилжиж байснаараа онцлог.

Хятадын мэргэн удирдагч Яо и Шуний<sup>60</sup> үед хүмүүс амар амгалан байдалд аж төрж ус уухын тулд худаг гаргаж, хоолтой болохын тулд газар хагалж их эрх чөлөөтэй өөрсдийнхөө хөдөлмөрөөр баяр баясгалантай амьдарч байв. Эрт үед Хятадад мөн л гурван засаглалын үндсэн зарчим үйлчилж байв.

Хятадын үндсэн хууль	Бусад орнуудын үндсэн хууль
Шалгалтын засаглал	Хяналтын засаглалыг багтаасан хууль тогтоох засаглал
Хууль тогтоох засаглалыг багтаасан эзэн хааны засаглал	Гүйцэтгэх засаглалыг багтаасан шалгалтын засаглал
Хяналтын засаглалыг багтаасан шүүх засаглал	Шүүх засаглал

Дээрх хүснэгтээс харахад Хятадын үндсэн хууль улс төрийн засаглалыг эзэн хааны засаглал, шалгалтын засаглал, хяналтын засаглал гэж хувиарласан асаглал байв. Гэхдээ эзэн хааны мэдэлд хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглал төвлөрсөн байв. Хятадад оршин тогтнож байсан гурван засаглалын хувиарлалтад шалгалтын засаглал их үр ашигтай, хамгийн чухал нь байсан. Орон нутагт шалгалт авахдаа шалгалтын байрны хаалгыг хатуу битүүмжилж байсан. Шаллагчид өөрсдийн үүрэгтээ чин үнэнч сэтгэлээр хандаж байсан ба шалгуулагчидтай үгсэхгүй, ажлыг үнэлэхдээ хувийн сонирхолдоо хөтлөгдөхгүй байх зарчмыг баримталж байсан байна. Бодоод үз л дээ хятадад шалгалтын ажил хэрэг ямар өндөр төвшинд нухацтай тавигдаж байсныг. Хожмоо энэ практик муудаж, албан тушаалаа урвуулан ашиглах үзэгдлүүд гарах болсон.

<sup>60</sup> Яо И Шунь Эртний Хятадын домогт удирдагч. МЭӨ 24-23-зуунд амьдарч байсан.

Хятад дахь хаант байгууллын үед хяналтын засаглалыг тусгай мэргэшсэн түшмэдүүд гүйцэтгэж байсан. Жишээ нь: Тан хааны хаанчлалын үед хянагч түшмэдүүд Цин<sup>61</sup>-ий хаанчлалын үед ордны байцаагч түшмэдүүд гэж байсан. Энэ хүмүүс ажил албандаа үнэнчээр зүтгэж алдаа дутагдал гарсан нөхцөлд үнэнийг л эзэн хаандаа зоригтой шударгаар хэлдэг байсан. Тэд зориг тэвчээр бүхий зан авиртай, шулуун шударга байдлаараа ялгарцгааж байв.

Миний үзэж байгаагаар эрх чөлөөнд тэмүүлэх, дэг журамд тэмүүлэх энэ хоёр хүч тэнцвэртэй оршиж байх ёстой. Аль нэг рүү нь туйлшруулж болохгүй. Физикт төвд тэмүүлэх, төвөөс зугтах хүчний хоорондын харьцааг хадгалах хуулийн адилаар тэдгээрийн хооронд тэнцвэрийн байдлыг хадгалж байх хэрэгтэй. Хэрэв гэнэт аль нэг үгүй болчихбол тухайн биет өөрийн ердийн байдлаа хадгалж чадахгүйд хүрдгийн адилаар. Зөвхөн энэхүү хоёр хүчний тэнцвэрийг хадгалж, тэдгээрийг зөв хослуулсан нөхцөлд л бүх юмсын тэнвэр бий болж манай дэлхий ертөнцийн бат тогтвортой байх чанарын хүчин зүйлс бүрэлдэнэ. Үндсэн хуулийг хөдөлгүүртэй (машин) зүйрлэж болно. Ийм асуудалд дутуу дулимаг ханддаг хүмүүст миний энэ харьцуулалт гайхаш төрүүлж магадгүй. Гэвч материаллаг ертөнцөд хөдөлгүүр үйлчилдэгийн адилаар хүмүүсийн хоорондын харилцаанд тэр бас оршин үйлчилж байдаг. Тэгэхлээр хууль бол хүмүүсийн хоорондын харилцааг удирдах хөдөлгүүр (машин) мөн.

Хувьсгалт үйл ажиллагаа явуулсан цагаасаа л эхлээд бид үндэсний үзэл санаа, ард түмний засаг, ард нийтийн сайн сайхан байдал гэсэн ардын гурван зарчмыг баримталж ирсэн. Энэ зарчим америкийн ерөнхийлөгч Линкольний томъёолсон: “of the people, by the people and for the people” зарчимтай дүйж тохирч байгаа юм. Эдгээр үгийг би тухайн үедээ “ард түмэн мэднэ, ард түмэн удирдана, ард түмэн ашиглана” гэж орчуулж байв. Ард түмэн “удирдаж” байгаа нөхцөлд л “ашиглаж” чадна. Хэрэв ард түмэн удирдах бололцоо нөхцөл байхгүй нөхцөлд тэд “ашиглах” боломжгүй. Хэрэв тэд “ашиглаж” чадахгүй байгаа бол “ард түмэн мэднэ” хэмээх зарчим худал зүйл болно.

“Ард түмэн удирдана” зарчмыг хэрэгжүүлэхийн тулд хүмүүст тэр хөдөлгүүрийг (машин) өгөх хэрэгтэй. Тэд өөрсдөө тэр хөдөлгүүрийг түргэн шуурхай, хөнгөөн хэрэгтэй зүг тийш залж чиглүүлэх болно. Энэ хөдөлгүүр (машин) бол үндсэн хууль.

#### Таван засаглалын үндсэн зарчмууд

Хууль тогтоох засаглал	Хяналтын засаглал
Шүүх засаглал	Шалгалтын засаглал
Гүйцэтгэх засаглал	

Дээрх хүснэгтээс харахад төрийн засаглал бие биенээсээ хараат бус таван: хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх, хяналын, шалгалтын засаглалд хуваагдаж байна.

<sup>61</sup> Таны хаанчлал 618-аас 907 онуудад Циний хаанчлал 1644-1911 онуудад оршин тогтнож байсан.

Гүйцэтгэх засаглалыг ерөнхийлөгч, хууль тогтоох засаглалыг- парламент, шүүх засаглалыг шүүгч нар төлөөлж байна. Шалгалтын болон хяналтын засаглалыг хэрэгжүүлэхэд мөн хараат бус байгуулагыг бий болгох шаардлага гарна. Таван засаглалын зарчмыг хэрэгжүүлсэн нөхцөлд төрөөс хүмүүс засаг захиргааны албан үүргийг гүйцэтгэхдээ зөвхөн үндсэн хуульд нийцүүлж хэрэгжүүлэхийг л шаардах болно. Ард түмний үйлчлэгчид өөрсдийн албан үүрэгт томилогдохоосоо өмнө шалгалт өгөх ёстой энэ нь хүмүүсийг ялгаваргүйгээр ашиглах явдалд цэг тавина гэсэн үг. Шалгалтгүйгээр бид эргэн тойрондоо байгаа авъяастай хүмүүсийг олж харахгүй, энэ утгаараа бид олон тооны үнэтэй цэнэтэй ажилтнуудаа алдаж байгаа хэрэг. Түүний хажуугаар төрийн албанд улс төрийн мэдлэггүй цөөнгүй хүмүүс шургалдаг. Энэ байдал албан тушаалаа урвуулан ашиглах, засгийн газрын ажил албыг хөсөрдүүлэх явдалд болон ард түмний бухимдал, дургүйцлийн өсөлтөд хүргэдэг.

Таван засаглалын бие даасан институтүүдийг бүрдүүлэхэд орон нутгийн өөрийн удирдлага хамгийн чухал бөгөөд түүгээр дамжиж ард түмний шууд засаглал хэрэгжинэ. Зөвхөн ард түмний шууд засаглал бол жинхэнэ ард түмний засаглал мөн. Ард түмний шууд засаглал үндсэн дөрвөн : сонгуулийн эрх, албан тушаалтныг сольж өөрчлөх эрх, хууль тогтооход санаачлагчтай байх ба санал асуулга явуулах эрхийг өөртөө агуулж байдаг. Хэрэв таван засаглалын зарчим-хөдөлгүүр болдог бол ард түмний шууд засаглал-үндсэн хуулийг ажиллуулж зохицуулагч оньсон түлхүүр юм. Ард түмэн шууд сонгуулийн тэр тусмаа албан тушаалтныг сольж өөрчлөх эрхтэй байх ёстой. Ард түмэн албан тушаалтныг сонгох, албан үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа нөхцөлд халж солих эрхийг эдлэх ёстой. Хууль тогтооход санаачлагатай байх гэж бидний нэрлээд байгаа эрхийг юу гэж ойлгох вэ? Энэ бол хэрэгтэй цагт нь шаардлагатай хуулийг бий болгох эсхүл хэрвээ ард түмэнд хор хохиролтой гэж үзэгдэж байгаа хууль тогтоох танхимаар батлагдсан аль нэгэн хуулийг өөрчлөхийн төлөөх ард түмний эрхийг хэлж байгаа юм. Ард түмний санал асуулга явуулах эрх гэж юу вэ? Хэрэв зээ сайн хууль хууль тогтоох танхимын дийлэнх гишүүдийн саналаар няцаагдсан тохиолдолд ард түмэн санал асуулгын замаар тэрхүү хуулийг дэмжин батлуулах эрхийг эдлээд зогсохгүй бас түүнийг түргэн батлах нөхцлийг хангана. Түүнийг бид санал асуулга явуулах эрх гэж нэрлэж байгаа бөгөөд дээр өгүүлсэн жишээн дээр хууль тогтоох танхимд хууль боловсрогдож, ард түмэн зөвхөн санал асуулгын замаар тэрхүү хуулийг дэмжсэнээрээ уг хуулийн батлагдах нөхцөлийг хангаж байгаа юм.

**Түлхүүр үг:** Синхайн хувьсгал, засаглал, үндсэн хууль, хувьсгал, засаглалын ардчилсан зарчмууд

**Товч хураангуй:** Сүн Ят Сэн нь азийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг байсан бөгөөд Хятадын анхны ерөнхийлөгч байв. Түүний 1924 онд бичсэн “Таван засаглалын үндсэн зарчмууд” өгүүллийг орчуулан хүргэж байна. Энэхүү өгүүлэлд хятадын нөхцөлд тохирсон ардын гурван зарчмын тухай сургаал, таван засаглалын онолын талаар тодорхой өгүүлсэн байдаг.

## **ABSTRACT**

Sun Yat-sen was one of the earliest and most influential political thinkers in Asia and were first president of the republic of china. He wrote "Five power principles" in 1924. In this article he discussed Three Principles of the People and Five power principles theory.